

ОРЧИН ҮЕИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ЯВДЛЫН ШИНЖ ХАНДЛАГА, ТАСЛАН ЗОГСООХ ЗАРИМ АСУУДАЛ

TENDENCY OF MODERN ORGANIZED CRIMINAL OFFENCES AND SOME PROBLEMS TAKEN TO DISCOURAGE



Э.ЧИМИДЛХАМ ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний туслах ажилтан, хууль зүйн магистр, цагдаагийн дэд ахлагч

CHIMIDLKHAM E. Assistant researcher of the Research and Development Institute, Law Enforcement University, law of master, Police junior sergeant

Товч агуулга: Энэхүү өгүүллээр орчин үеийн зохион байгуулалттай гэмт явдлын шинж, хандлага, цаашид түүнтэй тэмцэх эрх зүйн болон үйл ажиллагааны зохицуулалт судалж, таслан зогсоох зарим арга хэмжээний тухай саналыг дэвшүүлжээ.

Abstract: In this report some suggestions were put forward in order to discourage modern organized crimes. Analysis and research on characteristics, tendency as well as on legal basis of combating to this type of crime have been conducted.

Зохион байгуулалттай гэмт явдал нь маш нарийн чанд төлөвлөгдөж үйлдэгддэг тул түүнийг илрүүлэн шийдвэрлэхэд ихээхэн төвөг бэрхшээлтэй байдаг нь дэлхийн улс орнууд болон сүүлийн үеийн манай орны практикаас харагдаж байна. Энэхүү үзэгдэл нь мэргэжилтнүүд төдийгүй улс орон иргэдийн сэтгэлийг зовоосон асуудлын нэг болоод байгаа. Учир нь зохион байгуулалттай гэмт явдлын учруулах хор аюул хөнөөл нь асар их гэдэг нь ойлгомжтой.

Гэмт хэрэгтнүүд өөрсдийн мэдэлд хамгийн орчин үеийн зэвсэг техник, тээврийн хэрэгсэл, ямар ч төр удаан хугацаагаар хууль сахиулах, цагдаагийн байгууллагад төсөвлөж чадахгүй тийм их хэмжээний мөнгөтөй байдаг болсон. Ийм шалтгаанаар гэмт явдал өндөр зохион байгуулалттай бүтэц болж хувирсан. Энэ байдал нийгмийн аюултай үзэгдэлтэй амжилттай тэмцэх боломж олгохгүй байгаа юм. Төрийн удирдлагын хөшүүргүүд болон улс орон дахь эдийн засгийн явцын хяналт руу зохион байгуулалттай гэмт явдал ямагт тэмүүлдгийг дэлхийн туршлага харуулж байна.

Нийгмийн тогтолцоо солигдож бусад өөрчлөлт гарсан ч гэмт явдал байж л байсан одоо ч устаж үгүй болоогүй ирээдүйд ч удаан хугацааны туршид алга болохгүй.

Зохион байгуулалттай гэмт явдал нь идэвхтэй, гэмт хэрэг үйлдэх эрчимтэй шинжээрээ ердийн гэмт үйлдлээс ялгагдана. Гэмт явдал нь тавьж буй зорилго баримтлах хандлага өөрийн амьдралынх нь хэвшил болдог. Гэмт хэрэг байнга үйлдэх явдлыг баталгаатай болгох нөхцөлийг бүрдүүлэхийн тулд гэмт этгээдүүд болон тэдгээрийн хамтран хэрэг үйлдэгсэд гэмт нийгэмлэгт нэгддэг. Энэ нийгэмлэг нь байгууллагын хэлбэрээр зохион байгуулагдана. Ингэж нэгдэхдээ хатуу тогтсон бүтцийг эрхэмлэн үздэгийг практик харуулж байна. Байгууллагад гишүүд нь хэрхэн биеэ авч явах дэг, хатуу сахилга бат үйлчлэх ба байгууллагаа дэмжиж багагүй хөрөнгө зарцуулдаг. Зохион байгуулалттай гэмт явдал хүчээр дарамт шахалт үзүүлэх ажиллагаа нь янз бүрийн хэлбэр арга, явууллага үйлдэл, айлган сүрдүүлэлт ба тэдгээрийг хэрэгжүүлэх аргаар илрэн байна.

Хүч хэрэглэсэн зохион байгуулалттай гэмт хэргийн үйлдэх арга онц хэрцгий болж, хүнд, онц хүнд гэмт хэргийн тоо жилээс жилд нэмэгдэж¹⁸, төрийн бодлогод нөлөөлөхийг оролдох биеийн болон сэтгэл

¹⁸ "2013 оны байдлаар Улсын хэмжээнд 25362 онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 3273 хэргээр буюу 14,8 хувиар өссөн". ЦЕГ, ЭЦГ-ын 2013 оны үйл ажиллагааны товч танилцуулга. <https://prezi.com/vxvumssgchoj/copy-of/>

зүйн, эд хөрөнгийн дарамт үзүүлэн гэмт этгээдүүд төрийн албан хаагчдийг худалдан авч, засаглалын бүтцэд нэвтрэх, арилжааны банк, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжүүдийн удирдлагыг гартаа авах, далайлган сүрдүүлэх хандлага газар авах төлөвтэй боллоо.

Манай улсад бүртгэгдсэн зохион байгуулалттай гэмт хэргийн статистик судалгаа болон бусад байдлуудаас дүгнэн үзэхэд өнөөгийн цаг үед Монгол Улсад зохион байгуулалттай гэмт бүлэглэл байгаа бөгөөд үйл ажиллагаагаа явуулсаар байна.¹⁹ Монгол Улсад Зохион байгуулалттай үйлдэгдэж буй гэмт хэргийн төрөл болох хүн худалдаалах, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах, авилга, мөнгө угаахтай холбоотой гэмт хэргүүд ихээр үйлдэгдэж байна.

ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төвөөс эрхлэн гаргадаг улсын хэмжээний гэмт хэргийн статистик мэдээнд 2010 оны байдлаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэрэг²⁰ буюу өмнөх оноос 2,5 дахин²⁰, 2011 оны байдлаар хүн худалдаалах гэмт хэрэг 6 буюу өмнөх оноос 6 дахин.²¹ 2012 онд хүн худалдаалах гэмт хэрэг өмнөх оноос 50.0 хувиар, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл бодисыг хууль бусаар бэлтгэх олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах хэрэг өмнөх оноос 6,3 хувиар²², 2013 онд хүн худалдаалах гэмт хэрэг 1 хэргээр буюу өмнөх оноос 11,1 хувиар, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл бодисыг хууль бусаар бэлтгэх олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах хэрэг 46 хэргээр буюу өмнөх оноос 61.3 хувиар²³ тус тус өссөн байна.

Гэхдээ энэ нь дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн гэмт байгууллага сонгодог утгаараа бус Монгол Улсын онцлогийг илтгэх цөөн хүн амтай хот суурин газраа илүүтэйгээр нягтарсан улс төр эдийн засгийн тогтворгүй бодлого, соёл иргэншлийн

онцлогтой уялдан өвөрмөц хэлбэрээр оршин тогтнож байна.

Өнөөгийн гэмт явдлын агуулга нь уламжлалт хэллэгээр шунахай сэдэлтэй буюу орчин үеийн барууны криминалистуудын нэрлэсэнээр бизнесийн шинж чанар давамгайлах болсон нь гэмт явдлын бүтцэд нөлөөлж гол төлөв зохион байгуулалттайгаар гэхдээ хамгийн хэмнэлтэй, үр ашигтай хэлбэрээр зохион байгуулагдан ажиллахад хүргэж байна. Хуучин цагийн андгай тангараг өргөсөн, шивээс, хувцаслалтаар ижилсдэг, ураг овгийн, шашны гэх мэт хүн амын нийтлэг хүчин зүйлсэд суурилсан гэмт бүлэглэлүүд цөөрч оронд нь түргэн хугацаанд зохион байгуулагддаг, аль болох цөөн оролцогчтой, хэлцэлд суурилсан бүлэглэлүүд давамгайлах болсон.

Олон Улсын хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх практикт “Зохион байгуулалттай гэмт хэрэг” нэр томъёог эрүүгийн гэмт бүлгүүдийн нягт холбоо бүхий систем гэж үздэг.²⁴

Зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэж буй гадаадын зарим улсын туршлагаас дурьдахад²⁵:

ХБНГУ-д Ландтаг /Германы холбооны улсад багтдаг муж улсууд/ тус бүрт адилхан бүтэцтэй зохион байгуулалттай гэмт явдлын талаар нууц арга, хэрэгслээр мэдээ, мэдээлэл цуглуулдаг, хуримтлуулдаг, мэдээллийн солилцоо, ашиглах ажиллагааг зохицуулдаг нэгжүүдтэй байдаг байна. Эдгээр нэгжүүд бүхэлдээ эрүүгийн хэргийг мөрдөн шалгах департаменттай холбоотой ажилладаг байна.

Итали улсад цагдаагийн байгууллагын гурван үндсэн нэгж зохион байгуулалттай гэмт явдлын талаар нууц аргаар мэдээ, мэдээлэл цуглуулдаг, тэдгээрийн бүтцэд төрийн цагдаагийн газар, карбинерууд, гаалийн цагдаагийн газар, түүнчлэн хэдэн жилийн өмнө байгуулагдсан зохион байгуулалттай гэмт хэргийн талаар нууц аргаар мэдээ, мэдээлэл цуглуулах ба гүйцэтгэх ажлын операци зохиох чиг үүрэгтэй мафитай холбогдсон гэмт хэргийг мөрдөн шалгах зөвлөл (Direzione Investigativa Antimafia) гэгч байгууллага ордог байна. Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий эдгээр байгууллагууд тус бүртээ орон нутагт эдгээр гэмт хэргийг мөрдөн шалгах салбаруудтай байдаг. Эдгээр байгууллагуудын олж цуглуулсан мэдээ, мэдээллүүд Италийн Дотоодыг хамгаалах яамны цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх ба зохицуулах Удирдах газрын мэдээ, мэдээллийг боловсруулах Төвд хадгалагддаг. Мэдээ, мэдээллийг боловсруулах Төв нууц арга, хүч, хэрэгслээр мөрдөн шалгаж ирүүлсэн мэдээ, мэдээллийг цуглуулж, тэдгээрийг ангилж, хадгалж, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг

¹⁹ Тухайлбал; Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газрын мэдээллээр 2006-2013 онд буюу сүүлийн 8 жилд Хүн худалдаалах гэмт хэргийн 226 хохирогчтой 95 хэрэг бүртгэгдсэн байдаг. Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-ын мэдээллээр 2003-2014 онд буюу сүүлийн 12 жилийн байдлаар 554 хүн хүн худалдаалах хэргийн хохирогчоор тогтоогдсон байна.

²⁰ ЦЕГ-ын МСТ “Монгол улс дахь 2010 оны гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” 2011 он 10 тал

²¹ ЦЕГ-ын МСТ “Монгол улс дахь 2011 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх ажлын санал” 2012 он 12 тал

²² ЦЕГ-ыг МСТ “Монгол улс дахь 2012 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх ажлын санал” 2013 он 5-6 тал

²³ ЦЕГ-ыг МСТ “Монгол улс дахь 2012 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх ажлын санал” 2014 он 120, 122 тал

²⁴ Д.Адъяабазар, З.Төрмандах “Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэс” УБ 2005 он 21 дэх тал

²⁵ Л.Батдолгор “Шинэ төрлийн гэмт хэргийн өнөөгийн байдал”

бүхий холбогдох газруудад илгээдэг байна.

Ямайкийн цагдаагийн газарт зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх бүтэц байдаг ба энэ нэгж гэмт байгууллагатай холбоотой мэдээ, мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийдэг байна. Ийм мэдээллийг янз бүрийн эх сурвалжаас, түүний дотор бусад улсын зохион байгуулалттай гэмт хэргийг мөрдөн шалгах байгууллагуудтай хамтран ажиллаж цуглуулдаг. Гэмт үйл ажиллагаанд оролцогч этгээдүүдийг тогтоохын тулд тийм мэдээ, мэдээллүүдэд дүн шинжилгээ хийдэг байна.

АНУ зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэхийн тулд бусад орныг бодвол асар их туршлага хуримтлуулсан билээ. Иймдээ ч дэлхий нийтээр глаболчлагдаж байгаа чиг хандлагыг харгалзан бусад орнуудын цагдаагийн байгууллага, хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах тэдгээртэй туршлага, мэдээлэл солилцох зэрэг хамтын ажиллагаанд олон аргыг ашигладаг байна. Мөн зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэхийн тулд тусгай хуультай. Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцдэг тусгай прокурор, шүүгч, мөрдөн байцаагч нартай мөн гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилладаг юм.

Америкийн Нэгдсэн Улсад зохион байгуулалттай гэмт хэрэгтэй холбоотой гэмт үйл ажиллагааг мөрдөн шалгах гол байгууллага Холбооны Мөрдөх Товчоо, түүнээс гадна Хар тамхи, мансууруулах бодисын тухай хуулийг хэрэгжүүлэх удирдах газар, Дотоод орлогын алба, АНУ-ын Гаалийн алба, Цагаачлалын ба иргэний харъяаллын асуудал эрхлэх алба ба холбооны болон орон нутаг дахь зохион байгуулалттай гэмт хэргийг мөрдөн шалгадаг төрийн бусад байгууллагууд зохион байгуулалттай гэмт хэрэгтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр байгууллагуудын цуглуулсан мэдээ, мэдээллийг ашиглаж зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний стратегийг боловсруулдаг байна.

Оросын Холбооны Улсын Холбооны Аюулгүй Байдлын Албаны тусгай салбарууд өөрийн нууц эх сурвалжуудыг ашиглаж гадаадын иргэд болон хилийн чанадад зорчигч өөрийн иргэд, улс төрийн хэт даврагч, террорист чиглэлтэй хөдөлгөөнүүдэд нэвтэрч мэдээ, мэдээлэл олдог. Түүнээс гадна холбооны аюулгүй байдлыг алба ажилтнууд гадаадын фирмүүдтэй холбоотой болон хилийн чанадад үйл ажиллагаа явуулдаг худалдаа, арилжааны болон банкны үйл ажиллагааны данс, баримт бичигт нэвтрэх боломжтой байдаг байна. ОХУ-ын холбооны аюулгүй байдлын алба, Дотоод хэргийн яам зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд хэлбэрийн хувьд төстэй дараах чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

1. Зохион байгуулалттай гэмт хэргийн тухай ба авилгын тухай тэдгээрийн гэмт бүлэг, бүлэглэлийн тухай мэдээ, мэдээлэл цуглуулахад

чиглэсэн гүйцэтгэх ажлын арга хэмжээ зохиох, энэ зорилгоор зохион байгуулалттай гэмт хэргийн бүтцэд нэвтрэх ажлыг зохион байгуулах.

2. Мэдээллийн сан бий болгож, зохион байгуулалттай гэмт хэргийн бүтцүүдийн үйл ажиллагааны талаар дүн шинжилгээ хийх.
3. Гэмт хэргийн бүлэг, бүлэглэлийн толгойлогчид, тэдгээрийн гишүүдийг гүйцэтгэх ажлын аргаар шалгах.
4. Төрийн эрх барих ба гүйцэтгэх эрх мэдлийн авилгад автсан албан хаагчидыг илрүүлж, шалгах ажиллагааг зохион байгуулах.
5. ОХУ-ын нутаг дэвсгэр дэх гадаад улсуудын зохион байгуулалттай гэмт хэргийн бүтцэд нэвтрэхийн тулд гүйцэтгэх ажлын шугамаар мэдээ, мэдээлэл цуглуулж, тэдгээрийн эсрэг арга хэмжээг зохион байгуулах.
6. Гадаад улсуудтай экспорт, импортын талаар гэрээ байгуулахад ОХУ-ын эрх ашгийг хамгаалах арга хэмжээ зохиох, гадаад орнуудтай холбоотой гэмт хэргийн бүлэг, бүлэглэлийн үйл ажиллагааг баримтжуулах.
7. Идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг гэмт хэргийн бүлэг, бүлэглэлийг зохион байгуулах ба төрийн эрх барих болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын албан тушаалтнуудыг худалдан авах бололцоотой, бүх этгээд / эрүүгийн гэмт хэрэгтнүүд, сүүдрийн эдийн засгийн толгойлогч нар, олон усы хэмжээнд гэмт хэрэг үйлддэг луйварчид, залилан мэхлэгчид, гэмт үйлдлээр мэргэшсэн этгээдүүд / -ийн талаар байнга мэдээ, мэдээлэл цуглуулах.
8. Дээр дурьдсан этгээдүүдийн үйлдэл, холбоо харилцааг баримтжуулах.
9. Зохион байгуулалттай гэмт хэргийн бүтцүүдийг террорист, хэт даврагч үйл ажиллагаанд оролцохыг таслан зогсоох.
10. Гүйцэтгэх ажлын сэрэмжлүүлэх иж бүрэн арга хэмжээг хэрэгжүүлэх гэх мэт.

ОХУ-ын ХАБА ба ДХЯ-ны ажилтнууд хоорондоо зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх талаар харилцан туршлага солилцох нь энэ гэмт явдалтай амжилттай тэмцэл явуулахад ихээхэн ач холбогдолтой гэж үздэг байна.

Хятад улс Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч байна. Үүнд:

- Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тусгай хууль сахиулах байгууллага байгуулах, Гуан дун, Фу жиан, Шанхай зэрэг зохион байгуулалттай гэмт хэрэг ихээр гардаг газруудад зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тусгай байгууллагуудыг байгуулж ажиллуулж байна.
- Зохион байгуулалттай гэмт хэргийг судлах ажлыг

эрчимжүүлэх, зохион байгуулалттай гэмт хэргийн өөрчлөлт, хөгжил хандлагаар гэмт үйл ажиллагаа болон түүнд нийцсэн хуулийг анхааралтай судалж мэдээллийн сүлжээг байгуулж ажиллах.

- Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх. Зохион байгуулалттай гэмт хэргийн талаар нийтэд сурталчлах, таниулах, түүнтэй тэмцэхийн чухлыг ойлгуулж тэдний дэмжлэг тусалцааг авах.
- Гэрчийг хамгаалах. Гэрчийг болон түүний өмч хөрөнгө, аюулгүй байдлыг хамгаалах, ингэснээр нийгмийн гишүүдээс зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх оролцоог нэмэгдүүлэх гэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүдлэг байна.

Монгол улсын Засгийн газар 2005 онд Хүн худалдаалах, хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөрийг батлан, улмаар 2012 онд эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалах, биеийг нь үнэлүүлэн ашиглах бүх хэлбэрийг таслан зогсооход чухал ач холбогдолтой Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг Улсын Их Хурал баталсан ба үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд 2008 онд нэгдэн орсон.

Мөн 2010 онд БНХАУ-ын Макаогийн Засаг захиргааны онцгой бүсийн Засгийн газар хооронд “Хүн худалдаалахтай тэмцэх асуудлаар хамтран ажиллах” хэлэлцээрийг байгуулсан бөгөөд ингэснээр хүн худалдаалах гэмт хэргийн талаар харилцан мэдээлэл солилцох механизм бүрдсэн байна. Түүнчлэн ОХУ, БНХАУ, БНСА, БНКаУ, БНТУ-уудтай консулын зөвлөлдөх уулзалтуудыг 2011 оноос жил бүр зохион байгуулж, уулзалтын үеэр хүн худалдаалах болон мансуурах бодис зөөвөрлөх зохион байгуулалттай гэмт хэргийн талаар харилцан мэдээлэл солилцон цагдаа, тагнуулын байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, эрх зүйн тусалцаа үзүүлэх гэрээг байгуулан, гэрээний хүрэн дэх үүргийн биелэлтээ дүгнэх зэргээр санал солилцон ажилладаг байна.²⁶

Судлаачид, мэргэжилтнүүдийн зүгээс зохион байгуулалттай гэмт явдлын шинж, онцлогын талаар өгсөн дүгнэлт, тайлбаруудаас үзэхэд орчин үеийн зохион байгуулалттай гэмт явдал нь дараах шинжүүдийг зайлшгүй агуулж байна.

Нэг. Өндөр ашиг, бага эрсдэл: Ямар ч түвшинд зохион байгуулагдсан бүлэг, гэмт бүлэглэл нь ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж байна.²⁷ Өөрөөр хэлбэл,

зохион байгуулалттай гэмт явдал хууль бус арга замаар өндөр ашиг орлого олох боломж бүрдсэн тэр газар, улс оронд богино хугацаанд үүсч бүрэлдэж, хүрээгээ тэлдэг байна. Харин эсрэгээр нь хууль бусаар ашиг орлого олох боломж хязгаарлагдмал байгаа газрыг²⁸ зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд сонирхдоггүй буюу гэмт явдал зохион байгуулалттайгаар үйлдэгдэх нь бага байдаг нь ажиглагдаж байна. Эндээс өндөр хэмжээний ашиг орлого олж болох хууль бус үйл ажиллагаа зохион байгуулалттай гэмт явдал хоёр нь шууд хамааралтай болох нь харагдаж байгаа юм. Үүнээс гадна хууль бус бизнесийн үйл ажиллагаа нь байнга хууль сахиулах байгууллагын хяналт, хариуцлага тооцох үйл ажиллагаанд өртөх эрсдэлтэй байгаа тохиолдолд зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлүүд ийм эрсдэлтэй газрыг сонгодоггүй болох нь батлагдсаар байна.

Нөгөөтэйгүүр тодорхой хувь хүн, бүлэг этгээдийн ашиг сонирхлоос төдийлэн хамааралгүй байдаг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлийн үйл ажиллагаа ямар нэгэн субъектив хүчин зүйл (өшөө хорсол, итгэл үнэмшил г.м)-ийн нөлөөллөөс зайлсхийж ашиг орлого өндөртэй, эрсдэл багатай үйл ажиллагаанд голлон анхаарахад хүргэх болжээ.

Зохион байгуулалттай гэмт явдлын хүрээнд илэрч буй дээрх онцлог шинж нь орчин үед энэ төрлийн гэмт явдалтай тэмцэх шинэ стратегийг бий болгосон нь өндөр эрсдэл, бага ашиг гэсэн томъёололоор илэрхийлэгдэх болжээ.

Хоёр. Зохион байгуулалт: Бүлэг, бүлгүүдийн нэгдэл, хүнээс үл хамаарах байгууллагын тогтолцоо, гэмт нийгэмлэг: Зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэж ирсэн улс орнуудын туршлагаас харахад энэ төрлийн гэмт явдлыг бүрэн устгах боломж туйлын хомс болох нь харагддаг. Ялангуяа өндөр түвшинд зохион байгуулагдаж байгууллагын хэмжээнд нэгдэж, нягтарсан, хүнээс үл хамаарах бүтэц, зохион байгуулалттай болсон гэмт бүлэглэл, нийгэмлэгийг устгах, алга болгох зорилт тавих нь төдийлэн ашиггүй байна.

Үүний зэрэгцээ зохион байгуулалттай гэмт үйл ажиллагаа нь өөрийн гол онцлог болох “олон хүн”-ний хүчин зүйлийг ашиглаж гэмт үйл ажиллагаагаа мэргэжлийн, нарийн төлөвлөсөн, авлигаар хамгаалагдсан, аюулгүй байдлаа хангахын тулд нийгмийн бүтцийг ашигладаг, нийгмийн хүрээний олон давхрагад нөлөөлөх боломжтой зэрэг давуу талуудыг өөртөө бий болгосоор байна. Өгүүлэн буй, хүчин зүйлс нь энэ төрлийн гэмт явдалтай тэмцэхэд үүсэх гол бэрхшээлүүд аль ч цаг үед зохион байгуулалттай гэмт явдалтай дан ганц цагдаагийн

байна тэнд хүч хэрэгслээ төвлөрүүлдэг...” С.Нарангэрэл “Зохион байгуулалттай гэмт явдал” УБ., 1991 он 8 дахь тал “Баяжих, капитал хуримтлуулахыг гол зорилгоо болгодог...” Н.Жанцан “Криминологи” УБ., 2004 220 дахь тал

²⁸ Террорист үйл ажиллагаа явуулдаг гэмт бүлэглэлийг эс тооцвол

²⁶ <http://mfa.gov.mn> “Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх монгол улсын засгийн газрын ээлжит найм, есдүгээр илтгэл” 2014 он

²⁷ “Ашиг, орлого олох арвижуулах ямар боломж нөхцөл

байгууллага тэмцээд амжилт олсон түүх хомс байна. Харин зохион байгуулалттай гэмт үйл ажиллагааны энэхүү олон талт байдлын эсрэг төрийн болон иргэний нийгмийн хүрээний институтүүдийг оролцуулсан олон талт хамтын ажиллагаа явуулах нь ихээхэн амжилт олж байгаа ажээ. Өөрөөр хэлбэл, хууль сахиулах болон хяналт, шалгалтын үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага, иргэд, олон нийтийн дэмжлэг оролцоотойгоор зохион байгуулалттай гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх ажлуудыг хийж ирсэн олон улсын практик нь зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэхэд олон талт хамтын ажиллагааны стратеги чухал болохыг баталж байна.

Гурав. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэстэн дамнасан хамтын ажиллагаа: Орчин үеийн зохион байгуулалттай гэмт хэрэг нь үндэстэн дамнасан шинжтэй байгаа бөгөөд нэг улсын хууль сахиулах байгууллага дангаар тэмцэх бодит боломжгүй болжээ. Иймд үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй улс гүрнүүд хамтран тэмцэх хэрэгтэй болж байна. Тухайлбал, Хүн худалдаалах гэмт хэргийн хувьд ялангуяа манай орон мэт элсүүлэгч улсын хувьд гэмт этгээдүүд өөр улсын нутаг дэвсгэрт орогнож, хохирогчийг мөлжиж ашиглах үйлдэл мөн өөр улсын шүүх эрх мэдлийн хүрээнд явагдах тохиолдолд гэмт этгээдийг цээрлүүлэх, хохирогчийг эрх зүйн хамгаалалтад авах зэрэг ажиллагаа нь гэмт хэрэгтэн, хохирогчийн байрлаж байгаа оронтой хамтран ажиллахгүйгээр бүтэшгүй зүйл юм.

Үүнээс үүдэн үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэх олон улсын хамтын ажиллагааны стратегийг баримтлах нь зүйтэй байна.

Дүгнэлт, санал: Зохион байгуулалттай гэмт хэргийн тухай уламжлалт төсөөлөл нь нийгэмд оршин буй шинэ төрлийн зохион байгуулалттай гэмт үйл ажиллагааг олж харахгүй, тэдний үйлдэлд зохих ёсоор эрх зүйн үнэлгээ өгч чадахгүй, гэмт бүлэглэлд тооцохгүй байх нь зохион байгуулалттай гэмт хэргийг улам бүр даамжирах хүчин зүйл болж байна.

Зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэхэд манай улсын болон дэлхийн улс орнуудын хуримтлуулсан туршлага, ололт амжилтыг үгүйсгэхгүйгээр улам хөгжүүлэхийн зэрэгцээ, энэ төрлийн гэмт явдалтай тэмцэх, таслан зогсоох ерөнхий үзэл баримтлал, стратегийг дээр өгүүлэн буй гурван зарчмын хүрээнд нэгтгэн боловсруулах нь зүйтэй юм. Зохион байгуулалттай гэмт явдлыг таслан зогсоох арга техникийг төвлөрүүлэх, төгөлдөржүүлэх нь гэмт этгээдүүдэд хамгийн хүчтэй цохилт болно.

Зохион байгуулалттай гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажиллагааг үр нөлөөтэй болгохын тулд аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн үйл ажиллагааны хууль эрх зүйн орчинг судалж

ямар байгууллага, албан тушаалтантай²⁹ хамтран ажиллахаа зөв сонгох хэрэгтэй.

Дэлхийн бусад улсын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэж байгаа арга хэлбэр, туршлагаас харахад дэлхийн ихэнх улс орнууд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд онцгойлон анхаарч бие даасан, хараат бус албыг байгуулсан байна.

Шинэ арга барил, бодлогоор энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх шаардлага зүй ёсоор гарч байгаа энэ үед зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй, бие даасан байгууллагыг байгуулах шаардлагатайг харгалзан Мөрдөх албаны тухай хуулийг батлах нь зайлшгүй нэн тэргүүний арга хэмжээ юм.

Мөн энэ чиглэлээр нарийн мэргэшсэн тусгай мөрдөгчийг Хууль сахиулахын их сургууль болон гадаадын зарим оронд тусгайлан бэлтгэх нь зүйтэй.

Түүнчлэн, үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхийн тулд үндэсний эрх зүйн тогтолцоог сайжруулж, гадаад хамтын ажиллагаа, эрх зүйн харилцаа тусалцаа үзүүлэх үйл ажиллагааг сайжруулах нь зүйтэй гэж үзэж байна.

²⁹ Дараах албан тушаалтнууд,
Гаалийн ажилтан
Гадаад харилцаа, эрүүл мэнд, байгаль орчин, хөдөлмөрийн улсын байцаагч
Гал түймэртэй тэмцэх албаны ажилтан
- Нийгмийн хэв журам сахиулах олон нийтийн байцаагч
Хилийн болон гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн албаны ажилтан
Орон нутгийн байгаль орчны болон эрүүл мэндийн ажилтнууд
Нутгийн захиргааны байгууллагын ажилтан
Хохирогчид тусламж үзүүлэх ажилтан
Хэвлэл мэдээллийн ажилтан
Төрийн бус байгууллагууд